



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2026 оны 02 сарын 10 өдөр

Дугаар А/90

Есөнбулаг сум

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.6, 4.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2024 оны 17 дугаар тогтоолоор батласан "Аймгийн шагналын журам шинэчлэн батлах тухай"-ын 2 дугаар бүлгийн 2.1.7, 2.1.8, 4 дүгээр бүлгийн 4.7, 4.8 дахь заалт, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2026 оны 02 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2025 оны аймгийн "Тэргүүний хамт олон"-оор шалгарсан байгууллага, "Хөдөлмөрийн аварга"-аар шалгарсан иргэдийн нэрсийг нэгдүгээр хавсралтаар, зарцуулагдах зардлыг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

2.Зарцуулагдах 9,778,000 (Есөн сая долоон зуун далан найман мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Засаг даргын орлогч (М.Алтангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын *Д.Оны* 02 дугаар сарын *10*-ны өдрийн *1198* дугаар албан бичгийн 1 дүгээр хавсралт

Говь-Алтай аймгийн "Хөдөлмөрийн аварга"-ын нэрс

№	Овог нэр	Албан тушаал
Худалдаа, үйлчилгээ(бөөний болон жижиглэн худалдаа, нийтийн хоол ахуйн үйлчилгээ)		
1.	Б.Энхбаатар	"Хасагт Жаргалан" авто үйлчилгээний газрын үүсгэн байгуулагч
2.	Т.Алтантуяа	Ерөнхий боловсролын сургуулийн тогооч
Хөдөө аж ахуй		
3	Ч.Эрхэмбаяр	Мал эмнэлгийн газрын лабораторийн эрхлэгч
Байгаль орчин		
4	Д.Батмагнай	Байгаль орчны газрын дарга
Хууль сахиулах, аюулгүй байдал хангах		
6	Б.Батдорж	Онцгой байдлын газрын гамшгаас хамгаалах улсын байцаагч
6	Ц.Нямцэрэн	Дотоодын цэргийн 825-р ангийн эргүүл хамгаалалтын офицер
Төрийн захиргаа		
7	А.Мягмаршагдар	Бугат сумын ЗДТГ-ын дарга
Дэд бүтэц		
8	Д.Байгалмаа	Ундарга - Алтай ААТҮГ инженер
9	О.Баяртогтох	Тохижилт үйлчилгээний газрын цахилгаанчин
Боловсрол		
10	Ү.Баярмаа	ЕБС-ийн 1-р сургуулийн багш
11	Б.Түвдэндорж	ЕБС-ийн 1-р сургуулийн багш
Эрүүл мэнд		
12	Б.Ганхүрэл	Аймгийн Нэгдсэн эмнэлгийн их эмч
13	Н.Түмэндэмбэрэл	АШУҮИС-ийн сувилахуйн багш
Соёл,спорт, аялал жуулчлал, хэвлэл мэдээлэл		
14	Э.Отгонбаатар	Ардын дуу бүжгийн Алтай чуулгын дарга
Үйлдвэрлэл (жижиг дунд үйлдвэрлэл)		
15	Ц.Алтантуяа	Хоршооллын холбооны оёдолчин
16	Б.Булгамаа	Алтайн - Аз од ХХК Хүнсний технологич

Тэргүүний хамт олон

1 Төгрөг сумын эрүүл мэндийн төв

Аймгийн Засаг даргын ... оны ... дүгээр
сарын ...-ны өдрийн ... дугаар албан
бичгийн 2 дугаар хавсралт

**2025 ОНЫ ТЭРГҮҮНИЙ ХАМТ ОЛОН, ХӨДӨЛМӨРИЙН АВАРГУУДЫН
ШАГНАЛЫН ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Хөдөлмөрийн аварга өргөмжлөл	16	40,000	640,000
2	Мөнгөн шагнал	16	500,000	8,000,000
3	Өргөмжлөл	1	90,000	90,000
4	Мөнгөн шагнал	1	1,000,000	1,000,000
5	Үнэмлэх	16	3,000	48,000
Нийт дүн				9,778,000

__оОо__